


Written by hanoi

Wednesday, 24 January 2018 09:08 - Last Updated Wednesday, 24 January 2018 09:23

---

There are no translations available.



БНСВУ-ын Үндэсний Ассамблейн дарга, хатагтай Нгуен Тхи Ким Нганы урилгаар Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболд 1 дүгээр сарын 20-23-ны өдрүүдэд тус улсад албан ёсны айлчлал хийлээ.

Айлчлалын үеэр хоёр парламентын тэргүүн нар албан ёсны хэлэлцээ хийж, Монгол Улсын Их Хурал, БНСВУ-ын Үндэсний Ассамблей хоорондын хамтын ажиллагааны Санамж бичигт гарын үсэг зурав.

УИХ-ын дарга М.Энхболд ВКН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Нгуен Фу Чонг, Вьетнамын Ерөнхийлогч Чан Дай Куанг нарт бараалхаж, Ерөнхий сайд Нгуен Суан Фуктай уулзалт хийн, Ходоо аж ахуй, ходоогийн хөгжлийн сайд Нгуен Суан Гьонг, Вьетнам-Монголын Найрамдлын нийгэмлэгийн дарга Хо Суан Хунг нарыг хүлээн авч уулзав.

Албан ёсны айлчлалын үеэр, Монгол Улс, БНСВУ-ын уламжлалт найрсаг харилцааны нэгэнт хүрсэн түвшинг цаашид улам оргожүүлэх, хамтын ажиллагааны баримт бичгүүд, Засгийн газар хоорондын комиссын хуралдаанаас дэвшүүлсэн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэх нь харилцаа, хамтын ажиллагаанд чухал нөлөөтэй болохыг талууд онцлов.

УИХ-ын дарга М.Энхболдын энэ удаагийн айлчлалаар хоёр улсын хууль тогтоох дээд байгууллага- парламентууд, аюулгүй байдал, батлан хамгаалах, хууь, хүчний байгууллагуудын хооронд тогтоосон хамтын ажиллагааг бэхжүүлж, уулзалт, яриа хэлэлцээний давтамжийг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцож, боловсон хүчнийг чадавхижуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хамтран хийх, Вьетнамын цэргүүдийг “Хааны эрэлд” олон улсын сургуулилалтад оргоноор хамруулах, худалдаа эдийн засгийн чиглэлээр аж үйлдвэр, аялал жуулчлал, барилга, хот байгуулалт, дэд бүтэц, уул уурхай зэрэг салбарт Вьетнамаас хоронго оруулахыг дэмжих, худалдааны урсгалыг хоёр талтай болгож, экспорт, импортын бүтээгдэхүүний нэр торол, тоо хэмжээг

Written by hanoi

Wednesday, 24 January 2018 09:08 - Last Updated Wednesday, 24 January 2018 09:23

нэмэгдүүлэх, Монголоос гүн холдоосон мах, махан бүтээгдэхүүн экспортолж, Вьетнамаас загас агнуурын бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ импортлох шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн хяналт, хорио цээр, хил, гаалийн байгууллагуудад тулгамдаж буй асуудлыг цаг алдалгүй хамтран шийдвэрлэх, соёл, боловсрол, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах, нийслэл хотууд, орон нутгийн шууд хамтын ажиллагааг бий болгох зэрэг бүхий л салбарын харилцаа, хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүй санал солилцож, зарим үр дүнд хүрэв. Тухайлбал, Монгол Улсын Тов аймаг, Вьетнамын Хоа Бинь мужийн хооронд хамтран ажиллах Санамж бичиг байгуулж, Тов аймгийн ИТХ-ын дарга Ц.Энхбат, Хоа Бинь мужийн Ардын зовлолийн дарга Чан Данг Чинь нар гарын үсэг зурав.



Written by hanoi

Wednesday, 24 January 2018 09:08 - Last Updated Wednesday, 24 January 2018 09:23






Written by hanoi

Wednesday, 24 January 2018 09:08 - Last Updated Wednesday, 24 January 2018 09:23

---



БНУ-ын Ерөнхий сайд В.Оюун-Төр, Засгийн газрын тусгай зөвшөөрлийн үйлчилгээний газрын дарга М.Энхболд, БНСВУ-ын Ерөнхий сайд В.Триетангийн тэргүүлж байгаа төлөөлөгчдийн хамтаар Монгол Улсын Их Хурлын дарга М.Энхболдтай хийж байгаа албан ёсны айлчлалын үеэр.

Written by hanoi

Wednesday, 24 January 2018 09:08 - Last Updated Wednesday, 24 January 2018 09:23

---



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД БНСВУ-Д АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙЛЭЭ